



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 13, 15140-0036
Утас/Факс: (976-11) 31-83-92
E-mail: nok@ulaanbaatar.mn
http://www.nobg.ub.gov.mn

᠒᠐᠒᠒. 01. 05 № ᠐7

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тоо нэмэгдэж, тархах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан төр, хувийн хэвшлийн байгууллагуудын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар илэрсэн үед авах арга хэмжээний тухай түр зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийг чиг үүргийн хүрээнд холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллахыг мэдэгдье.

Хавсралт ᠒ хуудастай.

ШУУРХАЙШТАБЫН
ДАРГА Р.ДАГВА



Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай
штабын даргын 2022 оны 15 дүгээр
сарын 15-ны өдрийн 15 тоот албан
бичгийн хавсралт

9020020910 ± 9077073

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГАД КОРОНАВИРУСТ ХАЛДВАР
(КОВИД-19)-ААС СЭРГИЙЛЭХ, ТОХИОЛДОЛ ИЛЭРСЭН ҮЕД АВАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗӨВЛӨМЖ**

Сүүлийн өдрүүдэд нийслэл хотод коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тоо нэмэгдэж, халдвар тархах өндөр эрсдэлтэй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагууд халдвараас сэргийлэх, ажилтан, албан хаагчдын дунд батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед халдвар голомтлон гарах эрсдэлийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээнд энэхүү түр зөвлөмжийг мөрдөж ажиллана уу.

Нэг. Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх чиглэлээр:

1.1. Ажилтан албан хаагч, үйлчлүүлэгчдэд зориулан коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх талаарх мэргэжлийн байгууллагаас гаргасан зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг зэргийг нүдэнд харагдахуйц газар байрлуулах;

1.2. Ажилтан, алба хаагчид нь амны хаалт тогтмол зүүх, амны хаалтаа 2 цаг тутамд болон бохирдсон тухай бүр солих;

1.3. Ажлын байранд хүн хоорондын зайг 1-2 метрт барих, олноороо нэг дор бөөгнөрч цугларах, ажлын байранд хамтарч хооллох, цай уухыг хориглох;

1.4. Ажилтан албан хаагчдыг гар угаах, гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангах;

1.5. Ажлын байранд гадны хүн орохыг хориглох ба шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтныг дуудаж үйлчлүүлэх, хүлээн авч уулзах цэгийг тусад нь гаргах;

1.6. Ажлын цагаар зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд бусдын ерөөгөөр орохгүй байх, утсаар болон цахим хэлбэрээр шаардлагатай мэдээлэл солилцох;

1.7. Ажлын байранд агаар сэлгэлтийг тогтмол хийх;

1.8. Ажлын байранд тогтмол хугацаанд халдваргүйжүүлэлт хийлгэх;

1.9. Ажилтан, албан хаагчдыг коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунд бүрэн хамруулах;

1.10. Ажилтан, албан хаагчдынхаа дархлааг дэмжих ажлыг зохион байгуулах;

1.11. Ажилтан, албан хаагчид айл хэсэхгүй, зочин урихгүй байх, “гэр-ажил-гэр” маршрутыг баримталж ажиллах.

Хоёр. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед халдвар голомтлон гарах эрсдэлийг бууруулах, таслан зогсоох чиглэлээр:

2.1. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд ажлын цагаар хоолой хөндүүрлэх, хамар битүүрэх, найтаах, халуурах, ядарч сульдах, хуурай ханиалгах,

үнэр алдагдах зэрэг шинж тэмдэг илэрсэн хүн байвал эмчид хандаж халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдахыг зөвлөн ажлаас чөлөөлж явуулах, ажлын бус цагаар дээрх шинж тэмдэг илэрсэн бол удирдах ажилтандаа утсаар мэдээлж, халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдан “сөрөг” хариутай бол ажилдаа ирэхийг зөвлөх;

2.2. Хэрэв ажилтан, албан хаагч нь коронавируст халдвар (Ковид-19) батлагдсан бол энэ тухай байгууллагын удирдах албан тушаалтанд шуурхай мэдээлэх ба тухайн ажилтантай нэг өрөөнд эсхүл 2 метрээс дотогш ойр ажилладаг хүмүүсийг халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах;

2.3. Байгууллагын нэг өрөөнд 1-ээс дээш халдвар батлагдсан тохиолдолд тухайн өрөөний ажилтнуудыг, бусад өрөөнүүдэд алаг цоог халдвар илэрсэн тохиолдолд байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдахгүйгээр хавьтал болсон ажилтан, албан хаагчдыг цахимаар ажиллуулах боломжоор хангах;

2.4. Цахимаар ажиллаж байгаа ажилтан албан хаагчид нь халдвар хамгааллын дэглэмээ чанд мөрдөн гэрээс гарахгүй, айл хэсэхгүй, зочин урихгүй байх ба биеийн байдлаа ажиглах, хоолой хөндүүрлэх, хамар битүүрэх, найтаах, халуурах, ядарч сульдах, хуурай ханиалгах, үнэр алдагдах зэрэг шинж тэмдэг илэрвэл оршин суугаа хаягийн дагуу өрхийн Эрүүл мэндийн төвд хандаж зөвлөгөө авах;

2.5. Ажилтан, албан хаагчдын дунд халдвар батлагдсан тохиолдолд ажлын байранд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх ба зардлыг байгууллага өөрөө хариуцах.

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ШУУРХАЙ ШТАБ